




ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
3723 СЯА АМ.ДОЛЛАР



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
11.8%



НИЙТ ХАДГАЛАМЖ
17.2 ИХ НАЯД ТӨГ



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР
31.1 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР



ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
947 ТЭРБУМ ТӨГ



МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ
6%

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2020 онд: **2.1%**,
Инфляци: 2020 онд: **6.6%**,
Урсгал тэнцэл: 2020 онд: **-13%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2020 оны 4-р сарын тайланд тоймлосон байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2XR5XVj>


ДНБ-ий өсөлт: 2020 онд: **-1%**
Инфляци: 2020 онд: **5.6%**,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2020 онд: **-10.2%**- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2020 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2XR5XVj>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 11-р сарын байдлаар (3711) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 14.8 хувиар буурсан бол, зарлага 30 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 3711 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 862 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.



Ам.долларын ханш өмнөх сараас 3.6 төгрөгөөр буурсан байна.

Арваннэгдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 144 төгрөг буюу 5.4 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 3.6 төгрөг буюу -0.13 хувиар буурч, өмнөх улирлаас 0.03 хувиар өсч 2850 төгрөг болов. 10-р сард гадаад валютын нөөц 3.72 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 1 хувиар өсч, оны эхнээс 14 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.




Инфляцийн түвшин 3.5%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2020 оны 11-р сарын байдлаар өмнөх сараас 0.6 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар, оны эхнээс 2.9 хувь өсөв. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 6.9 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 3.2 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн ч тээврийн бүлгийн үнэ 5.2 хувиар буурсан байна.




Гадаад худалдааны тэнцэл 1969 сая.ам долларын ашигтай гарав.

2020 оны арваннэгдүгээр сард нийт барааны эргэлт 11742 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 7 хувиар буурсан бол экспорт өмнөх сараас 2.8, импорт өмнөх оны мөн үеэс 12.4 хувиар тус тус буурч гадаад худалдааны тэнцэл 1969 сая ам.долларын ашигтай гарав.



11-Р САРЫН ОНЦЛОХ: МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР

Эх сурвалж: www.mongolbank.mn

2020 оны гуравдугаар улирлын байдлаар Засгийн газрын нийт гадаад өр 8 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 31.1 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 2% (161 сая ам.доллар)-иар өссөн бол, Улсын нийт гадаад өр 1% (378,5 сая ам.доллар)-иар өссөн байна. Харин төв банкны өр 3% буюу 70.5 сая ам.доллар, хадгаламжийн байгууллагуудын өр 4% буюу 66.4 сая ам.доллараар тус тус өсчээ. Нийт гадаад өрийн 26%-ийг засгийн газрын өр, 7%-ийг Төв банкны өр, 6%-ийг хадгаламжийн байгууллагуудын өр, 26%-ийг бусад салбаруудын өр, 36%-ийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна.

САРЫН ОНЦЛОХ

БОДЛОГЫН ХҮҮГ 2 НЭГЖ ХУВИАР БУУРУУЛЖ 6 ХУВЬД ХҮРГЭВ

- Монголбанкны Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулж 6 хувь, банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2.5 нэгж хувиар бууруулж 6 хувьд тогтоох, Эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 1 хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, ЖДҮ, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх зэрэг багц шийдвэр гаргав.Тус шийдвэр "COVID-19"-ийн цар тахлын үед эдийн засаг, банк санхүүгийн салбарт үүсч буй сөрөг үр нөлөөг бууруулах, иргэд, бизнес эрхлэгчдэд, санхүүгийн байгууллагад учирч буй санхүүгийн хүндрэлийг зөөлрүүлэхэд чиглэжээ.

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙГ ХОЙШЛУУЛАХАД ХҮҮ ТООЦОХГҮЙ

- "COVID-19"-ийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Гамшгаас хамгаалах бүх нийтийн Бэлэн байдлын нөхцөл байдалд Монголбанк эдийн засаг, санхүүгийн зах зээлд үүссэн нөхцөл байдалтай уялдуулан санхүүгийн хүндрэлийг зөөлрүүлэх үүднээс зээлийн хугацааг өөрчилж, сунган, иргэдийг дэмжих шийдвэр гаргав. Ипотекийн зээл төлөлтийг хойшлуулж, зээл төлөлтөд хүү тооцон бодохгүй, төлөхгүй байх шийдвэрийг танилцуулав.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 11-р сар 2020 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 11-р сар 2020 он, Монголбанк
- www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn